



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 416

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны "Төрийн өмчид хөрөнгө шилжүүлэх тухай" 74 дүгээр тогтоол, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.5 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Нийслэлийн төр захиргааны автобааз" орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 147,300,000.00 (нэг зуун дөчин долоон сая гурван зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 29,375,760.00 (хорин есөн сая гурван зуун далан таван мянга долоон зуун жаран) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 3 автомашиныг төрийн өмчид хүлээн авч, төрийн өмчит хуулийн этгээдэд хавсралтад зааснаар эзэмшүүлж, бүртгэлд тусгахыг зөвшөөрсүгэй.

2.Улсын Ерөнхий Прокурорын газрын улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Тамгын газрын дарга Ц.Арвинбуудай, Баянгол дүүргийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Н.Энхтуяа, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газрын дарга Д.Болор, "Нийслэлийн төр захиргааны автобааз" орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дарга Ц.Батхуяг, Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга Б.Амартүвшин нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Комисс томилон хөрөнгө хүлээн авч, бүртгэлд тусгах ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган,"Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА





Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 10 дугаар сарын 28 ны өдрийн  
116 дугаар тогтоолын хавсралт

**ТӨРИЙН ӨМЧИД ХӨРӨНГӨ ХҮЛЭЭН АВЧ, БҮРТГЭЛД ТУСГАХ ТӨРИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭД**

Д/д	Шилжүүлэх байгууллага	Хөрөнгийн нэр, Улсын дугаар, Арлын дугаар	Үйлдвэрлэсэн он	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)		Бүртгэн авах байгууллага
					Улдэх өртөг	Улдэх өртөг	
1	"Нийслэлийн төр захиргааны автобааз" ОНӨҮГ	Ниссан Теана, 16-10 УНУ, 1N4AL3AP8GC184790, Суудлын автомашин	2016	59,900,000.00	8,050,760.00	51,849,240.00	Улсын Ерөнхий Прокурорын газар
2		Ниссан Теана, 08-94 УНУ, 1N4AL3AP0GC184735, Суудлын автомашин	2016	64,900,000.00	3,200,000.00	61,700,000.00	Баянгол дүүргийн Прокурорын газар
3	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар	Соната-7, 04-24 УНУ, КМНЕС41МВАА034118, Суудлын автомашин	2010	22,500,000.00	18,125,000.00	4,375,000.00	Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Тамгын газар
				<b>147,300,000.00</b>	<b>29,375,760.00</b>	<b>117,924,240.00</b>	
<b>НИЙТ ДҮН</b>				(нэг зуун дөчин долоон сая гурван зуун мянга)	(хорин есөн сая гурван зуун далан таван мянга долоон зуун жаран)	(нэг зуун арван долоон сая есөн зуун хорин дөрвөн мянга хоёр зуун дөчин)	